



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 07 сарын 05 өдөр

Дугаар 358

Улаанбаатар хот

「 Хөрөнгө балансаас балансад шилжүүлэх
тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын ерөнхий Прокурорын газрын харьяа Прокурорын газрын хөрөнгөд бүртгэлтэй, нийт 44,000,000.00 (дөчин дөрвөн сая) төгрөгийн балансын үнэ, 23,833,334.00 (хорин гурван сая найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин дөрвөн төгрөг) хуримтлагдсан элэгдэл бүхий автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Улсын ерөнхий прокурорын газрын туслах прокурор, Хэрэг эрхлэх газрын дарга С.Гансэлэм, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч А.Нарантуяа, харьяа газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг автотээврийн улсын бүртгэл, татварын бүртгэлээс шилжүүлэн арга хэмжээний биелэлтийг 2023 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Н.ГАНБОЛД

132605701
18-r_huraldaan.docx

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын
 2023 оны... дугаар сарын... өдрийн
 358... дугаар тогтоолын хавсралт



Улсын ерөнхий прокурорын газрын харьяа Прокурорын газрын үндсэн хөрөнгөд
 бүртгэлтэй балансаас балансад шилжүүлэх хөрөнгийн жагсаалт

д/д	Хөрөнгийн нэр	Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон	Тоо ширхэг	Нийт балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Шилжүүлэх байгууллага	Шилжүүлэн хүлээн авах байгууллага
1	Ниссан Патрол суудлын автомашин, улсын дугаар 80-00 ДОР, арлын дугаар JNTCSY61Z0580945	2011/2011	1	22,000,000.00	11,916,667.00	10,083,333.00	Дорнод аймгийн Прокурорын газар	Булган аймгийн Мал эмнэлгийн газар
2	Ниссан Патрол суудлын автомашин, улсын дугаар 80-00 ЗАН, арлын дугаар JNTCSY61Z0581060	2011/2011	1	22,000,000.00	11,916,667.00	10,083,333.00	Завхан аймгийн Прокурорын газар	Төв аймгийн Мал эмнэлгийн газар
	Нийт дүн		2	44,000,000.00 (дөчин дөрвөн сая)	23,833,334.00 (хорин гурван сая найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин дөрвөн төгрөг)	20,166,666.00 (хорин сая нэг зуун жаран зургаан мянга зургаан зуун жаран зургаа)		